

Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр

Баянговь сумын Засаг даргын Тамгын газар

2023 оны хагас жил

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
1	2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021 - 2024	60		90	Нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний техник, технологийг нэвтрүүлж, иргэдэд нарийн мэргэжлийн оношилгоо, үйлчилгээг хүргэхийн тулд Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат, биохимийн шинжилгээний аппарат, Цэрний хөргөгч зэргийг худалдаж авсан. Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппаратыг ажиллуулж эхэлсэнээс хойш 15 шинжилгээ уншуулсан байна.	100%
2	2.1.2. Эрэгтэйчүүдэд	1. Цэргийн насны 18-25 насны	2021 -	200		200	2023 оны 03 сарын 17-нд “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжье” өдөрлөг арга хэмжээ зохион байгуулсан. Тус	90%

	чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх	2024				арга хэмжээний хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, 45 иргэнийг хамруулсан. Мөн “Архи тамхины хэрэглээ, хор уршиг”, “Эр хүний 2 дахь зүрх болох түрүү булчирхай” гэсэн сэдвүүдээр сургалтыг зохион байгуулсан. Үзлэгээр артерийн гипертензитэй байж болзошгүй 3 иргэнийг, өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй 5 иргэнд зөвлөгөө өгсөн. үзлэгт хамрагдсан иргэдийн 40%-нь илүүдэл жин, таргалалттай байсанд хоололт болон дасгал хөдөлгөөн хийхийн ач холбогдолын талаар зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.	
3	2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	2021 - 2024	4.8		3.5	2023 он гарсанаар сүрьеэ өвчнийг илрүүлэх зорилгоор 3 хүний 6 сорьцийг тээвэрлэн явуулсан. Сүрьеэ өвчин илэрээгүй. Мөн сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр эмчлэгч их эмч Э. Нарангэрэл “Эмч зөвлөмж байна” буланд зөвлөгөө мэдээллийг видео хэлбэрээр бичин Эрүүл мэндийн төвийн фэйсбүүк болон сумын зарын группт байршуулсан. Тус видеог 409 иргэн үзэж, 95 лайк, 14 сэтгэгдэл, 3 хүн хуваалцсан байна.	70%
4	2.2.2. “Эрүүл, идэвхитэй	1. “Эрүүл, идэвхитэй	2022 - 2024	0		100	“Эрүүл идэвхитэй амьдрал” арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу үйл	100%

	амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх					ажиллагаануудыг зохион байгуулан ажиллаж байна. Цэцэрлэг болон ЕБС-н хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан. Мөн ЕБС-н сурагчид их завсарлагаанаар Түмэн дасгалыг хийж хэвшиж байна. 2023 оны 04 сарын 18 нд нийт ард иргэдийн дунд зөв хоололт, дасгал хөдөлгөөний ач холбогдолын талаархи сургалтыг зохион байгуулж, Эрүүл зөв өглөөний цай амталгаат үзэсгэлэн зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 80 гаруй иргэд хамрагдсан. Мөн Эрүүл мэндийн төвийн ажилчид ажлын байрны дасгалыг хийж хэвшиж бусад байгуулагуудыг уриалан урамшуулалт уралдаан зарлан ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн фэйсбүүк хуудсанд “Эмч зөвлөж байна” булан ажиллуулж сард 1 удаа эмч нар зөвлөгөө мэдээллийг өгөн ажиллаж байна. 3,4,5 сард 3 эмч зөвлөгөө мэдээллийн видеог байршуулсан ба нийт давхардсан тоогоор 2571 хүн үзэж, 392 лайк, 63 сэтгэгдэл, 29 хун хуваалцсан байна. Хүнсний бүтээгдэхүүний шошгын мэдээллийг ашиглан эрүүл хүнс сонгон хэрэглэх, давсны хэрэглээг бууруулах талаар сургалтыг хэвтэн эмчлүүлж байгаа иргэд болон ажилчиддаа 1 удаа орж, давс багатай өдрийн хоолоор үйлчилсэн.	
5		2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах	2021 - 2024	20000		20000	Сумын төрийн байгууллагууд, ард иргэд, сурагчдад хуваарийн дагуу спорт заалыг бүрэн ашиглуулж байна. Он гарсанаар 3 удаа	70%
6		3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах	2021 - 2024	2 0 0		2 1 0	Заал барих талбай болон заалны зураг төсвийг хийлгэсэн. Хөрөнгө мөнгөний асуудал шийдээгүй тул хүлээгдэж байгаа.	30%
7	2.3.2. Хүүхэд бүрийг	1. Тусгай хэрэгцээт боловсролын багш	2021 - 2024	96		40	Одоогоор хамрагдсан хүн байхгүй.	0%

	боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.	нарыг чадваржуулах сургалтад хамруулах						
8	2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.	3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах	2021 - 2024	97		100	Хамран сургах тойргийн хүүхдийн 44%-ийг үндсэн бүлэгт, 16%-ийг хувилбарт сургалтанд хамруулж байна. Бүлэг бүр сургалтын төвүүдийг төрөлжүүлэн тохижуулж хүүхэд сурч хөгжих сургалтын ая тухтай орчинг бүрдүүлж ажиллаж байна.	70%
9	2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	2021 - 2024	250		650	Энэ хичээлийн жилд 6-р ангид нэг суралцагчыг тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөрт хамруулаад байна. Баг тус бүрээс 2 бичиг үсэг үл мэдэгч иргэний сургалтад хамруулж мэргэжлийн багш нартай хамтран 14 хоногийн хугацаатай сургалтыг зохион байгуулж цаашлаад бие даалтаар багийн дарга нар болон өөрийн биеэр ирж шалгуулж байна.	70%
10		2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх	2021 - 2024	5000 0		15000 2	Насан туршийн боловсролын нэгжээр энэ жил 12 төрлийн сургалт нөлөөллийн ажлын нийт 827 иргэд, суралцагчдад зохион байгуулсан байна. Мөн цахим ур чадвар олгох 30 цагийн хөтөлбөрийг боловсруулан мэдээлэл зүйн багштайгаа хамтран 15 иргэнд үе шат дараатайгаар зохион байгуулж эхний сургалтуудыг явуулсан байна. Хавсралт : 5 зураг	100%

11	2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна.	1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах	2021 - 2024	10		8	Сумын хамгаалалтанд байгаа ТСҮХД газруудыг хамгаалах гэрээний хугацаа дууссан тул шинэчлэн хийхээр ажиллаж байна. 4-р багийн нутагт байх ТСҮХД газрууд, тусгай хамгаалалттай газарт өвөлжөө хаваржаатай айлуудын судалгааг гаргасан. Нийт 65 өрх айл байна. Биет бус өвийн талаарх сургалтыг 7,8,9-р ангийн сурагчдад хийсэн. Нийт 120 хүүхэд	50%
12	2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.	1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	2021 - 2024	3.2		25	Ураг удам уламжлалын Хонгор холбооны салбар холбоог сумын хэмжээнд шинэчлэн байгуулсан. Сургуулийн 7,8,9-р ангийн сурагчдад угийн бичгийн сургалтуудыг хийсэн. Нийт 136 хүүхэд	50%
3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
13	3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх	2021 - 2024	80		83	Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагалтыг Э-Тайлан цахим системд тайлагнаж байна. Баталгаажуулалт 100% тай байна.	50%
14		3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох	2021 - 2024	40		53	одоогоор хэрэгжээгүй. Нэвтрүүлээгүй байгаа.	0%

		энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх						
15	3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах	2021 - 2024	0		15	Сумын засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 10 ны өдрийн А/31 тоот захирамжаар Тус сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээг тодорхой хийж ажлын хэсэг хийсэн үүнд нийт 5-н багийн нутаг дэвсгэрийн 11 цэгт хэмжилт хийн га кординатыг авч 8,58 га газрын бүртэлжүүлэн мэдээллийн санг шинэчилэн холбогдох газарт судалгааг явуулсан мөн хяналтын тооллогыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн ахалсан ажлын хэсэг хийж гүйцэтгэсэн.	100%
16	3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ.	1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх	2021 - 2024	40		70	2022 онд Цагаан ямаат хоршооноос 250 ухна, 150 хуц Залаа жинстийн эдрэнгийн цагаан үйлдрийн шилмэл ухна худалдан авчирч малчидад тараасан.	30%
17		3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	2022 - 2024	0		100	Малын эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Мал эмнэлэгт хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн талаар иргэдэд сургалт мэдээллийг хийсэн. Сургалтанд нийт 480 хүн оролцоосон. Хавсралт : 1 зураг	90%

18		1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах	2021 - 2024	3	Засаг даргын нөөц хөрөнгөөс 800000 мянган төгрөгийг зарцуулсан.	2	Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаварын вакцинжуулалтад таван багийн 55 малчин өрхийн 871 тоо толгой үхэр сүргийн хамруулсан. Хавсралт : 8 зураг	100%
19	3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана.	2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих	2021 - 2024	0		7000	Мал эмнэлгийн нэгдсэн системээр 10 мал эмнэлгийн гэрчилгээ бичигдэж 4.5 тоон ноолуур, мах-100 кг, амьд мал-158 гэрчилгээ авсан байна.	70%
20		3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	2021 - 2024	0		15	Одоогоор хлорын шохой 200 кг, хамгаалалтын хувцас 50ш, автомакс 1 ширхэгийг тус бүр бүрдүүлсэн.	50%
4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
21	4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын	2021 - 2024	5 70 45.8		2 72 48	Авлигын гэмт хэргийн гаралтаас урьдчлан сэргийлэх үүднээс Баянговь мэдээ, мэдээлэл, Баянговь зарын группд АТГ цахим хуудсанд байршуулсан мэдээллийг	50%

	сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах					оруулж байна. Нийт 28 мэдээллийг оруулсан.	
22	4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ.	1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх	2021 - 2024	1000		1600	Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх үүднээс Малчидын зөвлөөгөөний үйл ажиллагааны үеээр иргэдэд малын эрүүл мэндийн тухай хууль, татварын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс мэдээлэл мэдээллийг иргэдэд хүргэсэн. Нийт 480 хүн хамрагдсан. Хавсралт : 1 зураг	70%
23	4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон	2. Төрийн болон байгууллагын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах.	2021 - 2023	183 , 13		70 , 0	Хадгалалт хамгаалатыг сайжруулах дээр архивын байнга болон түр хадгалах баримтуудыг тусгай архивын өрөөнд 2 тасалгаа архивын тавиур дээр бүх баримтыг 100 % хамгаалалтын хайрцаг хийж хадгалдаг. Хавсралт : 2 зураг	90%
24	хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг	3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх.	2021 - 2024	77,4		86	Баянговь сумын Засаг даргын Тамгын газар нь 2020 оны баримтыг цахим болон цаасаар Архив зүйн шаардлага, зааврын дагуу байнга хадгалах 136 баримтын 1552 хуудастай хадгаламжийн нэгжийг Архив бичиг хэргийн ажилтан Ж.Баяржаргал цахим баримт хүлээн авах хуваарьт хугацаанд төрийн архивт ирж ажиллан сум хариуцсан мэргэжилтэн	100%

	сайжруулна.						Э.Баттулгаар хянуулан алдааж засаж, Б.Оюунтуяа, Т.Ууганцэцэг тойрох хуудас зуруулан шалгуулж, Архив албан хэрэг хөтлөлтийн Улсын байцаагч В.Эрдэнэчимэгт Санхүүгийн баримт, 2020 оны дансаа шалгуулан алдааж засаж, тойрох хуудсанд гарын үсэг зуруулан өгсөн. Цахим баримтыг jpg-ээр скайнердан цахим хэлбэрээр файлын нэр өгч хадгалан, мастер эх хувиас "Photoshop" программд оруулан хуудасны дугаар бичвэрийг тодруулан цэвэрлэн засаж, ашиглалтын хувь бэлтгэх үйл ажиллагааг хийсэн. Цахим файлыг төрийн архивын цахим хариуцсан ажилтан Э.Баттулгад хянуулж цахимд шивэх эрхээ авсан. Баримтыг төрийн архивын www.e-document.gov.mn системд 2020 оны бүртгэл, дотоод товъёг шивж, товъёг бүрт хүний нэр, газар зүйн нэр, байгууллагын нэр гэсэн 3-н өгөгдөлд шивж Jpg өргөтгөлөөс pdt өргөтгөлд хөрвүүлж холбон, 4 хувь дансны хамт төрийн архивын тасгийн дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн хариуцсан ажилтан Э.Баттулгад хүлээлгэн өглөө.	
25		4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах.	2021 - 2024	0		0,22	Хийгдээгүй. Хүлээгдэж байгаа	0%
5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
26	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.	2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод тарих	2021 - 2024	24268,88		50000,50	Тэрбуммод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын мод тариалалтаар иргэн аж ахуйн нэгж байгууллагууд 4 төрлийн 1500 ширхэг мод сөөгийг тариалсан. Төрийн 7 байгууллага, 9 ажахуйннэгж, сургуулийн 250 сурагч, мөн малчид иргэд хамрагдаж ажиллаа. Хавсралт : 7 зураг	70%

27	5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах	1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах	2021 - 2024	6		3	Сумын Засаг даргын А/08 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан Цагаан голын сав дагуух булаг шандын эх, усан сангуудын хамгаалалтын бүсийн цэвэрлэгээг улирал бүр хийж усны эх үүсвэрт хяналтыг тогтмол тавьж байна. Хагас жилийн байдлаар Хэлтгий булаг, Гурван булаг, Нууцат, Бөөр булаг, сумын төвийн 2 гүн өрмийн худаг, 2 усан сангийн орчмын цэвэрлэгээг хийсэн.	70%
28	ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах	2021 - 2024	400		150	Тус сумд байгаль орчны чиглэлийн Хишиг хайрхан, Өнгөт гоёо гэсэн хоёр нөхөрлөл үйл ажиллагааг явуулж байна. Малчидын 5 бүлэг үйл ажиллагаа нь тогтмол явуулдаг. Их богдын байгалийн цогцолборт газар, Говийн тусгай хамгаалттай газрын биологийн олон янз байдлыг хамгаалах талаар хамтарч ажиллаж байна	50%
29	5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна.	1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	2021 - 2024	2		3	Хугацаа болоогүй.	0%
30	5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.	1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2021 - 2024	40		70	Сумын Засаг даргын А/08 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан Цагаан голын сав дагуух булаг шандын эх, усан сангуудын хамгаалалтын бүсийн цэвэрлэгээг улирал бүр хийж усны эх үүсвэрт хяналтыг тогтмол тавьж байна. Хагас жилийн байдлаар Хэлтгий булаг, Гурван булаг, Нууцат, Бөөр булаг, сумын төвийн 2 гүн өрмийн худаг, 2 усан сангийн орчмын цэвэрлэгээг хийсэн.	50%